



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.05.12 № 95
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Д.ЖҮГДЭР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч иргэн Доёдын Жүгдэрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2022-2023 оны төсвийн төсөөлөл, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Доёдын Жүгдэрийн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Доёдын Жүгдэрийн сонгуулийн мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Багахангай дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2022 ОНЫ
НӨХӨН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДОЁДЫН ЖҮГДЭРИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ИРГЭН ТӨВТЭЙ ДҮҮРЭГ
ДҮҮРГЭЭ БИ БИШ БИД ХӨГЖҮҮЛНЭ**

ЗОРИЛГО

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийнхээ эрх ашгийг удирдлага болгож, ардчилал, хүний эрх, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологи, мэдээллийн чиг баримжаатай улс төр, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино.

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харьяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр тэгш эрхээ, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл аюулгүй амьдарч сурч боловсрох эрхийг хангах:

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт хүнийг ялгаварлан гадуурхахыг зогсоох.
- Эрүүл иргэний төлөө эрүүл амьдрах дадал зуршилтай болох талаар иргэний нийгмийн байгууллагатай хамтран эрүүл урт наслах боломжийг олгох.
- Төрийн үйлчилгээг иргэн бүрд тэгш хүртэх боломжийг олгох.
- Авлигын гэмт хэргийг таслан зогсоох. Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх.
- Иргэний өмнөөс төрд дуу хоолой болох цонхыг нээж өгнө.
- Шударга, чадвартай иргэн төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах.


ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:

Монгол улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул төр, нийгмийн байгууллагаас дэвжих боломжийг олгох.

- Өрх бүрийг үйлдвэрлэгч болгох талаар төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.
- Төрөөс гэр бүлд дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдийг нээлттэй болгох.
- Өрхийн холбоог сайжруулж, хамтран эдийн засгийн эрх чөлөөнд хүрэх, гэр бүлийн орлого нэмэгдүүлж ажлын байрыг би болгох.
- Өрх, гэр бүлд хүчирхийлэлгүй байхад нийгмийн зорилтот төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.


ГУРАВ. ДҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

- Төрийн байгууллага бүр үйлчилгээний байгууллага байх стандартыг мөрдүүлэх.
- Иргэдийн оролцоотой Орон нутгийн хөгжлийн сангаас хийж хэрэгжүүлэх ажлын саналыг авч, иргэн төвтэй дүүрэг, хороо болох нөхцөлийг бүрдүүлнэ.
- Бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, бизнесээ тэлэх, ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж дэмжиж ажиллана.
- Архи, мансууруулах бодис болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллана.
- Дүүргийн залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжиж ажиллана.



- Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.
- Дүүргийн мал бүхий иргэд, уяач зэрэг өрхийн орлогоо нэмэгдүүлж байгаа өрхүүдийг дэмжиж ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН НЭР ДЭВШИГЧ
ДОЁДЫН ЖУГДЭР...../гарын үсэг/



Handwritten signature